



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 4370

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "г", Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, "Барилгын тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Цагаандэлгэр сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын хүчитгэл хийх ажил, Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн барилгын чанарыг газар дээр нь шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Чагнаадорж	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын дарга)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	(Аймгийн Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Д.Нэргүй	(Аймгийн ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
	Э.Энхмэнд	(Аймгийн ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Э.Цэрэннадмид	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга, авто замын хяналтын улсын байцаагч)

Хоёр. Цагаандэлгэр сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын хүчитгэл хийх ажлыг боловсруулсан зураг төсөвт тусгасан ажлыг нэг бүрчлэн шалгах, Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн барилгын чанарыг газар дээр нь үзэж танилцаж, тооцоо судалгаа гаргах ажлыг ажлын хэсэг (Э.Чагнаадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010221